




СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТООЛЛОГЫН ДҮН



Улаанбаатар хот 2026 он



2025 оны мал тооллогын дүн  
69 117 ↓ 1 071(1.5%)

1 576 ӨРХийн малын тоо

45 ААНБ-ын малын тоо

64 282 (93.0%)

↓ 2 261(3.4%)

↑ 1 190(32.6%)

4 835(7.0%)

↑ 2 396(13.1%)

20 739  
(30.0%)



↓ 364(1.4%)

25 462  
(36.8%)



↓ 1 114(8.8%)

11 555  
(16.7%)



↓ 1 987(14.8%)

11 361  
(16.5%)



5 473



71



5



683 880



508



80



МОНГОЛ УЛАС  
МАСЛАХ, АЖААХИЙН  
УРГАХААНЫ  
МОНГОЛ УЛАС

## ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Монгол Улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томьёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн "в", 18 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1667 дугаар захирамжийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн А/704 тоот захирамжийн дагуу мал, тэжээвэр амьтдын тооллогыг 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулах товын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт мал, тэжээвэр амьтантай өрх, аж ахуй нэгж, байгууллагыг тоолох ажлыг зохион байгуулав.

Энэхүү танилцуулгад орж байгаа статистикийн үзүүлэлтүүдийг дүүргийн мал, тэжээвэр амьтдын 2025 оны тооллогын мэдээллийг боловсруулж, Үндэсний Статистикийн хорооноос баталж зөвшөөрсөн, олон улсын стандартад нийцсэн аргачлалын дагуу тооцож, үр дүнг гаргалаа.

## ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх:** Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

**Малчин өрх:** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эхүүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

**Малчид:** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 Адуу, үхэр = 1 бод, 1 тэмээ = 1.5 бод, 6 хонь = 1 бод, 8 ямаа = 1 бод

**Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:** 1 тэмээ = 5 хонь, 1 адуу = 7 хонь, 1 үхэр = 6 хонь, 1 хонь = 1 хонь, 1 ямаа = 0.9 хонь

**Нас гүйцсэн мал:** Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай, 5 ба түүнээс дээш настай Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

**Бог мал** - тухайн жилийн төл малаас бусад насны мал Өсвөр насны мал:

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

**Төл мал:** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч:** Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эх малыг хэлнэ.

**Малын тоо, толгойн өсөлт:** Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана.

Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоо гэх нийт малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

**Төллөлтийн хувь:** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100- гаар үржүүлнэ.

**Бойжилтын хувь:** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100- гаар үржүүлнэ.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25, Азарга - 12-15, Бух - 35-45, Хуц, ухна - 25-30

**Малын зүй бус хорогдол:** Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь:** Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Малын хэрэглээний зарлага:**

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Хүнсний хэрэглээний малын тоо= Алдсан мал+Зах зээлд борлуулсан+Аж ахуйн дотоодод хэрэглэсэн+(Бусдад шилжүүлсэн – Худалдаж авсан, шилжижирсэн).

Бусдад шилжүүлсэн>=Худалдаж авсан, шилжиж ирсэн  
Учир нь худалдаж авсан эсвэл шилжиж ирсэн нэг хэсэг малаа идсэн байж болно.  
Идээгүй тохиолдолд тэнцэж байх учиртай.

**Малын хашааны хангамж:** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

**Тэжээл хангамж:** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент:** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг.

Үүний тулд дараахь итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Хадлан өвс	0.45
Таримал тэжээл	0.35
Даршны ургамал	0.25
Гартэжээл, хужир шүү	1.0
Төмс ногооны хаягдал	0.22
Үр тарианы хаягдал	0.9
Лай	0.4
Сүрэл	0.25

**Малын тэжээлийн ангилал:** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.




# МАЛ АЖ АХУЙ

## 2025 онд дүүргийн хэмжээнд 69.1 мянган толгой мал тоологдлоо.

Сонгинохайрхан дүүрэгт 2025 оны мал тооллогоор нийт 69117 толгой мал тоологдсон нь 2024 оноос 1071 (1.5%) толгой малаар буурсан байна. Нийслэлийн хэмжээнд 2025 онд 423592 толгой мал тоологдсон бөгөөд үүний 16.3 хувийг Сонгинохайрхан дүүргийн мал эзэлж байна. Малын тоо хэмжээ 2020-2022 оны хооронд өссөн бол 2022 оноос хойш бага багаар буурсан байна.

**ЗУРАГ 1. МАЛЫН ТОО, оноор**



Малын тоог таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад адуу 2396(13.1%) толгойгоор өссөн байна. Харин тэмээ 2(100%), үхэр 2566(9.9%), хонь 1921(15.2%), ямаа 2397(18%) толгойгоор тус тус буурсан байна.

2025 онд нийт мал сүргийн 22916(32.2%) бог мал, 46201(67.8%) бод мал тус тус эзэлж байна.

Иргэдийн хувийн мал өмнөх онд 70125 толгой байснаас тайлант онд 64285 толгой болж 5840(8.3%) толгой малаар буурсан байна. Аж ахуйн нэгж, байгууллагын мал өмнөх онд 3699 толгой байснаа тайлант онд 4832 толгой болж 1133(30.6%) толгой малаар өссөн байна.

**ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО төрлөөр, оноор**

Малын төрөл	2021	2022	2023	2024	2025	Өсөлт, бууралт 2024/2025*	
						Тоо	Хувь
<b>Малын тоо, бүгд</b>	<b>82 358</b>	<b>83 687</b>	<b>73 824</b>	<b>70 188</b>	<b>69 117</b>	<b>-1 071</b>	<b>-1.5</b>
Тэмээ	11	23	3	2	0	-2	2 дахин буурсан
Адуу	13 125	13 926	15 838	18 343	20 739	2 396	13.1
Үхэр	24 248	26 764	25 712	25 826	25 462	-364	-1.4
Хонь	21 688	20 917	17 130	12 669	11 555	-1 114	-8.8
Ямаа	23 286	22 057	15 141	13 348	11 361	-1 987	-14.9
Хонин толгойд шилжүүлснээр*	280 063	298 949	295 910	308 049	319 725	11 676	0.6

\* Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

## ХҮСНЭГТ 2.

### МАЛЫН ТОО төрлөөр, хороогоор

Хороо	2024	2025	Үүнээс: малын төрлөөр				Өсөлт, бууралт	
			Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Дүн	Хувь
			толгой					
<b>Дүн</b>	<b>70 188</b>	<b>69 117</b>	<b>20 739</b>	<b>25 462</b>	<b>11 555</b>	<b>11 361</b>	<b>-1 071</b>	<b>-1.5</b>
21	60 213	59 724	16 560	23 290	10 119	9 755	-489	-0.8
32	7 813	7 854	3 401	1 785	1 214	1 454	41	0.5
33	1 396	1 163	571	314	136	142	-233	-16.7
34	756	376	207	73	86	10	-380	-50.3
36	10	-	-	-	-	-	-10	10 дахин буурсан

2025 онд дүүргийн 21-р хороо 489(0.8%) толгой малаар, 33-р хороо 233(16.7%) толгой малаар, 34-р хороо 380(50.3%) толгой малаар тус тус буурсан байна. Харин 32-р хороо 41(0.5%) толгой малаар өссөн байна.

## ХҮСНЭГТ 3.

### НИЙТ МАЛД ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН малын төрлөөр, оноор

Нийт мал	2021	2022	2023	2024	2025
	Хувь				
Тэмээ	0.01	0.03	0.004	0.003	0
Адуу	15.9	16.6	21.5	26.1	30.0
Үхэр	29.4	32.0	34.8	36.8	36.9
Хонь	26.3	25.0	23.2	18.1	16.7
Ямаа	28.3	26.4	20.5	19.0	16.4

Нийт мал сүргийн 20739(30.0%) адуу, 25462(36.9%) үхэр, 1155(16.7%) хонь, 11361(16.4%) ямаа тус тус эзэлж байна. Малыг нийт дүнд эзлэх хувийн жинг өмнөх онуудтай харьцуулахад адуу, хонины эзлэх хувийн жин нэмэгдэж, үхэр, ямааны эзлэх хувийн жин багассан байна.

**Малтай өрх, малчдын тоо:** 2025 оны мал тооллогоор нийт 69117 толгой мал тоологдсон нь 2024 оноос 1071(1.5%) толгой малаар буурсан байна. 2025 оны мал тооллогын дүнгээр малтай өрх 1572, үүний дотор 1219 малчин өрх мал аж ахуй эрхэлж байна. Өнгөрсөн оноос малтай өрхийн тоо 45 өрхөөр, малчин өрхийн тоо 31 өрхөөр хасагдсан байна.


## ХҮСНЭГТ 4.

### МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН НАСНЫ БҮЛЭГ хүйсээр, оноор

Он	Нийт өрх	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Түүний ам бүлийн тоо	Малчдын тоо	Хүйс		Насны бүлэг		
						Эрэгтэй	Эмэгтэй	15-34 насны	35-54 насны эм, 35-59 насны эр	55 ба түүнээс дээш насны эм, 60 ба түүнээс дээш насны эр
2021	1 495	642	853	3 037	1 104	729	375	203	765	136
2022	1 557	605	952	3 443	1 304	844	460	227	870	207
2023	1 611	641	970	3 491	1 314	854	460	250	926	138
2024	1 617	367	1 250	4 490	1 716	1 109	607	327	1 065	324
2025	1 576	353	1 219	4 381	1 805	1 100	705	302	1 139	364


ЗУРАГ 2.

МАЛЧДЫН ТОО хүйсээр, оноор



ЗУРАГ 3.

МАЛЧДЫН ТОО насны бүлгээр



Малчдыг насны бүлгээр авч үзвэл 15-34 насны 302(16.7%), 35-54 насны эм, 35-59 насны эр 1139(63.1%), 55 ба түүнээс дээш насны эм, 60-аас дээш насны эр 364(20.2%) хүмүүс байна. Нийт малчдын 705(30.1%) эмэгтэй малчид байна.

**Мал төллөлт, төл бойжилт:** 2025 онд 27212 төл гарсны 25856(95%) төл бойжиж байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 1295(4.8%) толгой төлөөр буурсан байна. Бойжуулсан нийт төлийн 4557(17.6%) унага, 11529(44.6%) тугал, 5396 (20.9%) хурга, 4374(16.9%) ишиг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.

ТӨЛ БОЙЖИЛТ төлийн орлого, зарлага, төрлөөр

Малын төрөл	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Худалдсан	Шилжүүлсэн
	толгой						
Бүгд	27 212	1 356	25 856	2 300	62	10 087	117
Унага	4 820	263	4 557	234	7	908	10
Тугал	11 874	345	11 529	371	20	6 484	107
Хурга	5 789	393	5 396	550	25	1 093	0
Ишиг	4 729	355	4 374	1 145	10	1 602	0

**Малын хэрэглээний орлого зарлага:** Оны эхэнд тоологдсон малын 3052(4.4%) толгой малыг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна. Хүнсэнд зарцуулсан малын 1087(35.6%) үхэр, 881(28.9%) хонь, 789(25.8%) ямаа, 295(9.7%) адууг тус тус хүнсэнд зарцуулсан байна.

### ХҮСНЭГТ 6.

### МАЛЫН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр

Төрөл	Орлого			Хасагдсан					Хөөвөр, ноос, ноолуур самнасан малын тоо
	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Шилжүүлсэн	Алдсан, улгайлагдса нолдохгүй байгаа	Зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хоргодол	
толгой									
Адуу	4 303	530	3 880	947	108	4 717	295	290	814
Үхэр	3 359	136	5 329	715	34	7 712	1 087	359	908
Хонь	1 886	75	3 412	587	8	5 013	881	325	5 033
Ямаа	2 074	53	3 927	514	2	6 428	789	373	5 981
<b>Дүн</b>	<b>11 622</b>	<b>794</b>	<b>16 548</b>	<b>2 763</b>	<b>152</b>	<b>23 870</b>	<b>3 052</b>	<b>1 347</b>	<b>12 736</b>

Дээрх хүснэгтээс харахад энэ жилийн малын орлого талд мал тооллогоор худалдаж авсан 11622 толгой, бэлэн тоологдсон төл 16548 толгой, шилжиж ирсэн 794 толгой мал байна. Зарлага талд шилжүүлсэн 2763 толгой, хүнсэнд хэрэглэсэн 3052 толгой мал байна. Харин 23870 толгой малыг зах зээлд борлуулсан нь өмнөх оноос 4752(24.9%) толгой малаар илүүг борлуулсан байна. Зүй бусаар хоргодсон 1347 толгой мал байна. Үүний 290(21.5%) адуу, 359(26.6%) үхэр, 325(24.1%) хонь, 373(27.7%) ямаа тус тус эзэлж байна. Хөөвөр, ноос, ноолуур самнасан малын тоо нь тоологдсон нийт 69117 толгой малаас 12736 толгой мал байгаа нь 18.4%-ийг эзэлж байна.

**Малын хээл хаялт, сувайралт:** 2025 онд оны эхний хээлтэгч малын 9405(26.2%) тэнцэх хээлтэгч мал төл өгөөгүй ба үүний 6565(69.8%) эх мал сувайрсан, 1455(15.5%) эх мал хээл хаясан байна. Энэ нь өмнөх оноос сувайрсан мал 922(12.3%) толгойгоор, хээл хаясан мал 463(24.1%) толгойгоор тус тус буурсан байна.

### ХҮСНЭГТ 7.

### ТӨЛЛӨХ МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

Малын төрөл	Оны эхний хээлтэгч	Доод наснаас төллөсөн	Нэмэгдсэн	Хасагдсан	Хээл хаясан	Сувайрсан	Төллөсөн
	толгой						
Гүү	7 723	49	1 536	1 094	724	1 670	4 820
Үнээ	14 932	89	1 355	2 046	371	2 085	11 874
Эм хонь	6 007	55	797	1 707	168	699	4 285
Эм ямаа	7 229	125	724	2 058	192	1 111	4 717
<b>Бүгд</b>	<b>35 891</b>	<b>318</b>	<b>4 412</b>	<b>6 905</b>	<b>1 455</b>	<b>6 565</b>	<b>25 696</b>

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Дүүргийн нийт мал сүргийн 35891(5169%) нь хээлтэгч мал, 1184(1.71%) нь хээлтүүлэгч мал байна. Малын үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад дүүргийн хувьд нэг хээлтүүлэгчид дунджаар 74 эм хонь, 87 эм ямаа ногдож, хээлтүүлгийн тохироо алдагдсан байна.

### ХҮСНЭГТ 8.

### ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО төрлөөр, оноор

Төрөл	2021	2022	2023	2024	2025	Өсөлт, бууралт	
						Тоо	Хувь
	толгой						
Азарга	557	607	736	828	834	6	0.7
Бух	238	269	260	226	186	-40	-21.5
Хуц	161	229	128	212	81	-31	14.6
Ухна	40	138	111	87	83	-4	-4.6
<b>Бүгд</b>	<b>1 096</b>	<b>1 244</b>	<b>1 235</b>	<b>1 353</b>	<b>1 184</b>	<b>-169</b>	<b>-12.5</b>

**Хээлтэгч мал:** 2025 оны мал тооллогоор 35891 толгой хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2017(5.3%) толгой хээлтэгч малаар буурсан байна.

### ХҮСНЭГТ 9.

### ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО төрлөөр, оноор

Төрөл	2021	2022	2023	2024	2025	Өсөлт, бууралт	
						Тоо	Хувь
	толгой						
Гүү	5 337	5 354	6 364	7 866	7 723	-143	-1.8
Үнээ	13 659	15 048	14 845	15 807	14 932	-875	-5.5
Эм хонь	11 376	10 644	9 110	6 831	6 007	-824	-12.1
Эм ямаа	12 460	11 026	8 537	7 404	7 229	-175	-2.4
<b>Бүгд</b>	<b>42 836</b>	<b>42 087</b>	<b>38 856</b>	<b>37 908</b>	<b>35 891</b>	<b>-2 017</b>	<b>-5.3</b>

Нийт хээлтэгч малын 7723(21.5) гүү, 14932(41.6%) үнээ, 6007(16.7%) эм хонь, 7229(20.1%) эм ямаа тус тус хээлтэгч мал эзэлж байна.

**Бэлтгэсэн хадлан тэжээл:** Дүүргийн хэмжээнд 2025 онд 22.6 мянган тонн хадлан, гар тэжээл 1.1 мянган тонн, хужир шүү 332.2 тонныг тус тус бэлтгэсэн байна. Өмнөх онтой харьцуулахад хадлан 4014.8 (15.1%), гар тэжээл 98.3(5.3%), хужир шүү 39.3 (10.6%) тонноор тус тус буурсан байна.

### ХҮСНЭГТ 10.

### БЭЛТГЭСЭН ХАДЛАН ТЭЖЭЭЛ, хороогоор

Хороо	Бэлтгэсэн хадлан	өөрсдийн бэлтгэсэн	Таримал тэжээл	Бэлтгэсэн дарш	Гар тэжээл	Хужир шүү	Төмс, хүнсний ногооны хаягдал	Үр тариа хаягдал	Сүрэл
	ТОНН								
1					2.4		0.4	2.5	
2			0.5				1.2	5.4	
5	0.27				4.7			4	
7	4		1						
10			3				3	4.01	
11								2	
21	21 594	4 268.45	1 909.24	635.7	971.6	268.9	183	278.7	17
32	808.1	42.5	9	37	96.5	32	2	6.5	
33	58.2	13	45.2	1	1.5	0.3		26.3	
34	92	6	86			1			
40			6.6				0.3	2.5	
41			7					7	
42	0.1		0.8		0.5		0.9	278.7	
<b>Бүгд</b>	<b>22 556.67</b>	<b>4 330</b>	<b>1 952.6</b>	<b>673.7</b>	<b>1 077.2</b>	<b>332.2</b>	<b>190.8</b>	<b>342.3</b>	<b>17</b>

**Тэжээвэр амьтад:** Мал, тэжээвэр амьтдын 2025 оны тооллогоор 5473 гахай, 71 туулай, 684519 шувуу, үүнээс 683880 тахиа, 80 цацагт хяруул, 51 галуу, 508 бөднө, 5 илжиг тус тус тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад гахай 346(5.9%), туулай 91(56.2%) тус тус буурсан бол шувуу 339305 (98.3%), илжиг 5 (1.6 дахин их) тус тус өссөн үзүүлэлттэй байна.


### ХҮСНЭГТ 11. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО ТӨРЛӨӨР

Төрөл	Бүгд	Үүнээс:							
		Хээлтэгч		Хээлтүүлэгч		Төл		Бусад	
		Оны эхний	Бэлэн тоологдсон хээлтэгч	Оны эхний	Бэлэн тоологдсон хээлтүүлэгч	Оны эхний	Бэлэн тоологдсон төл	Оны эхний	Бэлэн тоологдсон
Гахай	5 473	685	245	156	774	96	30	59	67
Шувуу	684 519	262 339	208 401	500	470 240	220	70	101	189
Тахиа	683 880	261 665	208 348	331	469 682	136	54	82	108
Галуу	51	45	11	16	40	10	5	4	11
Цацагт хяруул	80	31	35	5	61	12	10	3	19
Бөднө	508	598	7	148	457	62	1	12	51
Туулай	5		3		3		1		1
Илжиг	71 90		4	49	45	31	1	17	15
Бусад	67	70	10	41	39	46	22	40	28

Гахай, шувуу тэжээдэг иргэд, аж ахуйн нэгжүүд 2025 онд 340.4 мянган тонн гахайн мах үйлдвэрлэж, 331.3 мянган тонн гахайн махыг 5.2 тэрбум төгрөгөөр борлуулсан байна. Харин 684.5 мянган шувуунаас 74.9 тэрбум өндөг үйлдвэрлэж 74.0 тэрбум өндөгийг 37.0 тэрбум төгрөгөөр борлуулалт хийсэн байна.

**Гэрийн тэжээвэр муур, нохой:** 2025 оны байдлаар гэрийн тэжээвэр 15125 нохой, 921 муур байна. Өмнөх оны дүнтэй харьцуулахад 58(0.4%) нохойн тоо буурсан бол 357(38.8%) муурны тоо өссөн байна.

### ЗУРАГ 3. НОХОЙ, МУУРНЫ ТОО, ОНООР



Хороо	Нохойны тоо		Муурны тоо	
	2024 он	2025 он	2024 он	2025 он
<b>Нийт</b>	<b>15 183</b>	<b>15 125</b>	<b>564</b>	<b>921</b>
1	709	711	61	58
2	769	769	23	23
3	704	703		1
4	523	523	32	32
5	387	378		
6	203	196	5	5
7	475	437		19
8	298	298		
9	467	446		1
10	516	469		28
11	584	535		29
12	25	21		
13	12	13	3	4
14	23	23	2	2
15	18	24	14	8
16	13	13	3	3
17	27	36	6	6
18	25	25	10	10
19	25	25	12	12
20	105	64	6	6
21	973	913	19	240
22	242	243		
23	284	284	11	11
24	498	478	44	36
25	161	161	1	1
26	228	446	13	15
27	15	10	11	10
28	427	427	13	13
29	10	10	6	6
30	213	213		
31	405	410	11	12
32	63	66	138	140
33	2 435	2 465		
34	224	224	6	6
35	430	439	23	21
36	514	541	35	25
37	24	24	1	1
38	12	12	2	2
39	351	345	5	11
40	511	515	17	22
41	496	496	4	4
42	466	393	16	81
43	293	301	11	17